



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2016 оны 07 сарын 04 өдөр

Дугаар А/258

Улаанбаатар хот

Чиглэл батлах тухай

Монгол улсын Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2, Өрсөлдөөний тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх заалтыг тус тус үндэслэн, хүн амын эрүүл мэндийн эрэлт хэрэгцээнд нийцсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зохистой бүрдлийг бий болгох зорилгоор ТУШААХ нь:

1. “Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 2016-2017 онд баримтлах чиглэл”-ийг хавсралтаар баталсугай.

2. Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 2016-2017 онд баримтлах чиглэлийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Хяналт, шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газар /С.Төгсдэлгэр/-т үүрэг болгосугай.

3. Энэ тушаал гарсантай холбогдуулан “Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 2014-2016 онд баримтлах чиглэл батлах тухай” 2014 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн 298 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.



САЙД

С.ЛАМБАА

080932

Эрүүл мэнд, спортын сайдын
2016 оны 07 сарын 04 -ны өдрийн
А/258 дугаар тушаалын хавсралт



ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХОД 2016-2017 ОНД БАРИМТЛАХ ЧИГЛЭЛ

Нэг. Нийтлэг зүйл

1. Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл (цаашид “Тусгай зөвшөөрөл” гэх) хүсэгчийн хүсэлтийг хэлэлцэж, шийдвэр гаргахад энэхүү баримтлах чиглэлийг удирдамж болгоно.
2. Тусгай зөвшөөрөл олгох үйл явц нь “Эрүүл мэндийн байгууллага байгуулах хэрэгцээ шаардлагыг тодорхойлох” ба “Тусгай зөвшөөрөл олгох” гэсэн үе шаттай хэрэгжих бөгөөд энэхүү баримт бичигт заасан зөвшөөрөл олгох тэргүүлэх чиглэл болон хязгаарлах чиглэлийг үндэслэнэ.
3. Тусгай зөвшөөрөл олгох тэргүүлэх чиглэлд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ болон салбарын хүний нөөцийн хөгжлийн тогтолцоонд олон улсын стандарт, оношлогоо, эмчилгээний дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэхэд тэргүүн ээлжинд үндэсний хөрөнгө оруулалт, улмаар гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих зарчим баримтлана.
4. Тусгай зөвшөөрөл олгоход баримтлах энэхүү чиглэл нь тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллагаас томилогдсон ажлын комисс болон эрүүл мэндийн чиглэлээр аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсэгч аж ахуйн нэгж байгууллагад хамаарна.
5. Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын дэргэдэх тусгай зөвшөөрлийн ажлын алба хүн амын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хэрэгцээ, шаардлагыг 2 жил тутамд үнэлэн, үнэлгээний дүнг дараагийн 2 жилд баримтлах чиглэлийн саналын хамт 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ЭМСЯ-ны дэргэдэх Эрүүл мэндийн байгууллагын тусгай зөвшөөрлийн комисст ирүүлнэ.

Хоёр. Тусгай зөвшөөрөл олгох тэргүүлэх чиглэл

2.1. Улсын хэмжээнд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх болон гадаадын хөрөнгө оруулалттай эрүүл мэндийн байгууллагад дараах чиглэлээр тусгай зөвшөөрөл олгоно. Үүнд:

2.1.1. Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан Монгол улсад оношлох, эмчлэх боломжгүй төрөлжсөн мэргэжлийн тусламж үйлчилгээ

2.1.2. Хөнгөвчлөх тусламж үйлчилгээ

2.1.3. Лабораторийн тусламж үйлчилгээ

2.1.4. Импорт орлох эм, эмнэлгийн хэрэгсэл, багаж, тоног төхөөрөмж, түүний дагалдах хэрэгсэл, протез болон ахуйн шавж, мэрэгч устгах, ариутгах, халдваргүйжүүлэх бодисын үйлдвэрлэл эрхлэх;

2.2. Тухайн орон нутгийн засаг захиргаанаас эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлэх асуудлыг шийдэж чадаагүй алслагдсан байршилд байрлан, хүн амд тусламж, үйлчилгээг ойртуулж, хүртээмжийг нэмэгдүүлсэн тусламж үйлчилгээг дэмжинэ.

Гурав. Тусгай зөвшөөрөл олгоход хязгаарлалт хийх чиглэл

3.1. Үйл ажиллагааны болон байршлын давхардал бүхий дараах эрүүл мэндийн байгууллагын төрөл, үйлчилгээ:

- Бүх төрлийн клиник, эмнэлэг, сувиллын тусламж, үйлчилгээ;
- Эмийн сангийн үйлчилгээ;
- Хараа зүйн тусламж, үйлчилгээ;
- Эмчилгээний гоо заслын үйлчилгээ;

3.2. Үндэсний болон гадаадын хөрөнгө оруулалт бүхий дараах эрүүл мэндийн байгууллагын төрөл, үйлчилгээ:

- Биологийн идэвхт бүтээгдэхүүн импортлох, худалдах;
- Зах зээлийн тандалт судалгаагаар эмийн нэр төрөл, тоо хэмжээ нь хангалттай нь тогтоогдсон эм, эмнэлгийн хэрэгсэл үйлдвэрлэх, импортлох, ханган нийлүүлэх;
- Хэрэгцээг судалж тогтоогоогүй, ижил төстэй технологиор үйлдвэрлэсэн, зах зээлд нэвтэрсэн эм, эмнэлгийн хэрэгсэл, оношлуур;